

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	12
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ХИЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ  
САЙЖРУУЛАХ БҮС НУТГИЙН  
ТӨСЛИЙН УДИРДАГЧ Ж.БАТБАЯР  
ТАНАА

2020.04.24 № 06/1312  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага


Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл нь төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*Ц.Наранчимэг*

Ц.НАРАНЧИМЭГ



## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн удирдагч Ж.Батбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төслийн нэгжийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн чанарын хяналтын менежер Х.Дорж, ахлах аудитор Т.Сугарсүрэн, аудиторын туслах Т.Энхжаргал, П.Ганчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2019 оны санхүүгийн тайланг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн MON/3387/0097 тоот дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь хилийн үйлчилгээг сайжруулах замаар гадаад худалдааг илүү шуурхай, боловсронгуй болгох, бараа эргэлтийг нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдаа эрхлэхэд зарцуулж буй зардал бууруулах, цаг хугацааг хэмнэхэд оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

1. Алтанбулаг боомтын барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх, 1.8 км хатуу хучилттай авто зам барих, Сүхбаатар хилийн боомтод хилийн хяналтын байгууллагуудын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор барих, Алтанбулаг, Бичигт, Замын-Үүд боомтуудын гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх;
2. Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем /КАИС/-ийг шинэчлэх, Сүлжээний дэд бүтэц, тоног төхөөрөмжийг өргөтгөх, шинэчлэх;
3. Монгол Улсад Гадаад худалдааны цахим нэг цонхны үйлчилгээ нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд тайлант онд төлөвлөн 94.5 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл нь Монгол Улсын Засгийн Газар болон Азийн Хөгжлийн Банк хооронд байгуулсан 2016 оны 07 дугаар сарын 11-ний өдрийн 3387-МОН тоот зээлийн хэлэлцээрээр байгуулагдсан. Зээлийн хэлэлцээрт 2017 болон 2018 онд тус бүр нэг удаа өөрчлөлт орсон. 2018 оны нэмэлт өөрчлөлтөөр төслийн дуусгах хугацааг 2023 он дуустал сунгасан.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, болон дараахь журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалын хавсралт “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, Засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт өөрчлөлт ороогүй байна.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа "Acoluos" программ хангамж ашигладаг байна.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 42,639.0 мянган төгрөгөөр тооцсон нь төсөл хэрэгжүүлэх хугацаанд зээлээр олгогдож буй санхүүжилтийг үр ашигтай, хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулаагүй байх эрсдэл үүсэх магадлалтай гэж үзсэнтэй холбоотой болно.

## 2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,948,250.3 мянган төгрөгөөр буюу 183 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,434,100.7	2,415,080.9	980,980.2
Авлага			
Урьдчилгаа	5,003.3	1,077.3	(3,926.0)
Бараа материал	1,083.4	554.2	(529.2)
БЗЭБуй бусад эргэлтийн хөрөнгө		1,958,705.7	1,958,705.7
Үндсэн хөрөнгө	166,512.3	179,531.9	13,019.6

<b>Нийт хөрөнгө</b>	1,606,699.7	4,554,950.1	2,948,250.3
Өр төлбөр	49.0	135,626.6	135,577.6
Засгийн газрын оролцоо	1,606,650.7	4,419,323.5	2,812,672.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	1,606,699.7	4,554,950.1	2,948,250.4

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь Азийн хөгжлийн банкнаас санхүүжилт орж ирсэнтэй холбоотой юм.

Борлуулах Зорилгоор Эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө дансанд 2019 оны Алтанбулаг хилийн боомтын авто зам, авто зогсоолын барилга, Сүхбаатар хилийн боомтын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор барилгатай холбоотой гарсан 1,958,705.7 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд Бодь элетроникс ХХК-ийн Гаалийн Ерөнхий Газарт нийлүүлсэн гаалийн автоматжуулсан мэдээллийн систем /КАИС/-ийг сайжруулах, сүлжээний дэд бүтцийг өргөтгөх, тоног төхөөрөмжийн барьцаа 134,926.6 мянган төгрөг, мөн оффисын түрээсийн үлдэгдэл төлбөр 700.0 мянган төгрөг байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

*Хүснэгт 2. Нийт орлогын батлагдсан төсөв, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагаанаас санхүүжих		75,195.5	75,195.5	100
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,751,031.9	6,439,870.2	688,838.3	112
<b>Нийт дүн</b>	5,751,031.9	6,515,065.8	768,033.9	113

Тайлант онд гадаадын эх үүсвэрээс 5,751,031.9 мянган төгрөгийн орлого төсөвлөснөөс гүйцэтгэлээр 6,439,870.2 мянган төгрөг байна. Гадаад эх үүсвэрийн санхүүжилт нь Азийн хөгжлийн банкны шууд төлбөр ба Төсөл хэрэгжүүлэх нэгжээр дамжуулан орж ирдэг. 2019 оны гүйцэтгэлээрх санхүүжилт нэмэгдсэн нь 6 сард ашиглагдах урьдчилгаа төлбөр нэмэгдсэнтэй холбоотой.

*Хүснэгт 3. Төсвийн зарцуулалт*

*/мянган төгрөг/*

Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал зардлын дүн	1,621,430.0	1,446,188.9	175,241.1	89.2
Хөрөнгийн зардал	4,129,601.9	4,128,223.8	1,378.1	99.9
<b>Нийт дүн</b>	5,751,031.9	5,574,412.7	176,619.2	96.9

Тайлант онд нийт 5,574,412.7 мянган төгрөгийн зардал гүйцэтгэлээр гарсан ба үүнээс урсгал зардалд 1,446,188.9 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 4,128,223.80 мянган төгрөг зарцуулагдсан. Хөрөнгийн зардлын дүнгийн 1,958,705.7 мянган төгрөг Санхүүгийн байдлын тайлан дээр Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөд бүртгэгдсэн байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 8 эрсдэл тодорхойлж нийт 8 горим сорил хэрэгжүүллээ.



### **2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөлд тайлант хугацаанд хийхээр төлөвлөсөн ажлуудаас дараах ажлуудыг гүйцэтгээгүй байна.

1. Алтанбулаг хилийн боомтын барилга байгууламжийн өргөтгөл шинэчлэлийн барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж, ажлыг эхлүүлэх нь 2, 3 дугаар улиралд хэрэгжихээр төлөвлөсөн боловч гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажил хүлээгдэж байгаа шалтгаанаар,
2. Сүхбаатар боомтын нэг цэгийн үйлчилгээний цогцолборын барилгын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулж, тендерийг зарлах ажил нь 1, 2 дугаар улиралд хэрэгжихээр төлөвлөсөн боловч урьдчилсан төсөв нь 1.5 сая доллар байсан бөгөөд экспиртизээр батлуулсан төсөв 1.7 сая доллар болсон. Үүнийг төслийн баримт бичигт тусгахын тулд төслийн Худалдан авалтын Төлөвлөгөөг шинэчлэн тусгах шаардлага гарсан зэрэг шалтгаанаар тайлант хугацаанд уг төлөвлөгөөт ажлууд хийгдээгүй. Иймээс дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж авч үзлээ.

### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, худалдан авалт, тендер болон бусад холбоотой 9 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### **2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан, хэрэгжилт 100 хувьтай байна

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, НББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>1,434,100,670.46</b>	<b>2,415,080,920.86</b>
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	7,869,850.82	72,245,193.92
Банкинд байгаа бэлэн мөнгө /гадаад валютаар/	1,426,230,819.64	2,342,835,726.94
<b>Урьдчилж төлсөн зардал</b>	<b>5,003,333.18</b>	<b>1,077,331.33</b>
Урьдчилж төлсөн зардал	5,003,333.18	1,077,331.33
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,083,431.26</b>	<b>554,214.50</b>
Бэлэн бүтээгдэхүүн	200,000.00	-
Хангамжийн материал	32,727.26	-
Түлш, шатах тослох материал	850,704.00	554,214.50
<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	<b>1,958,705,698.87</b>
БЗЭ буй эргэлтийн бус хөрөнгө	-	1,958,705,698.87
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,440,187,434.90</b>	<b>4,375,418,165.56</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		
<b>Биет хөрөнгө</b>	<b>164,312,294.95</b>	<b>179,165,225.05</b>
Авто-тээврийн хэрэгсэл	156,000,000.00	192,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл Авто-тээврийн хэрэгсэл	(24,700,000.00)	(40,300,000.00)
Машин, тоног төхөөрөмж	37,223,520.00	40,761,692.00
Хуримтлагдсан элэгдэл Машин тоног төхөөрөмж	(18,215,334.32)	(29,723,913.92)
Тавилга, аж ахуйн эд хогшил	16,638,545.45	20,831,100.01
Хуримтлагдсан элэгдэл Тавилга эд хогшил	(2,634,436.18)	(4,403,653.04)
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>2,200,000.01</b>	<b>366,666.62</b>
Программ хангамж	3,400,000.00	3,400,000.00
Хуримтлагдсан элэгдэл Программ хангамж	(1,199,999.99)	(3,033,333.38)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>166,512,294.96</b>	<b>179,531,891.67</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,606,699,729.86</b>	<b>4,554,950,057.23</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Ажиллагчидтай холбогдсон өглөг	48,999.76	-
Байгууллагад төлөх өглөг	-	135,626,550.00
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>48,999.76</b>	<b>135,626,550.00</b>
Урт хугацаат зээл	-	-
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	-	-
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>48,999.76</b>	<b>135,626,550.00</b>
Засгийн газрын хувь оролцоо	-	-
Өмнөх үеийн үр дүн		1,606,650,730.10
Тайлант үеийн үр дүн		2,812,672,777.13
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,606,650,730.10</b>	<b>4,419,323,507.23</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГИЙН /ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,606,699,729.86</b>	<b>4,554,950,057.23</b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,114,320,755.52</b>	<b>7,036,245,227.20</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,114,320,755.52</b>	<b>7,036,245,227.20</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,114,320,755.52</b>	<b>7,036,245,227.20</b>
<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,106,734,488.46</b>	<b>6,975,403,804.70</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,951,684.40	17,151,158.50
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,096,082,804.06	6,439,870,190.65
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	700,000.00	518,382,455.55
Бусад орлого	7,586,267.06	60,841,422.50
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>932,948,436.42</b>	<b>1,565,368,623.99</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>460,786,146.56</b>	<b>1,565,368,623.99</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>460,786,146.56</b>	<b>1,563,413,036.45</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>309,739,817.13</b>	-
Үндсэн цалин	309,739,817.13	-
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,168,784.06</b>	-
Тэтгэврийн даатгал	37,168,784.06	-
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>48,599,999.98</b>	<b>53,256,818.18</b>
Байрны түрээс	48,599,999.98	53,256,818.18
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,917,586.85</b>	<b>16,723,242.98</b>
Бичиг хэрэг	1,946,685.49	1,102,973.61
Тээвэр, шатахуун	5,990,744.90	3,822,473.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,076,395.65	5,340,569.94
Ном, хэвлэл	1,507,200.00	2,910,506.01
Аж ахуйн материал худалдан авах зардал	2,396,560.81	3,546,720.42
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>499,545.45</b>	-
Урсгал засвар	499,545.45	-
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,195,581.59</b>	<b>39,669,620.26</b>
Гадаад албан томилолт	0.00	27,030,340.26
Дотоод албан томилолт	3,187,949.00	12,639,280.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,007,632.59	0.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,692,397.55</b>	<b>1,423,052,225.18</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,192,500.00	1,418,440,399.51
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,600,000.00	1,584,875.95
Даатгалын үйлчилгээ	1,321,515.00	2,385,513.00
Тээврийн хэрэгслийн татвар	199,564.00	221,564.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	378,818.55	419,872.72
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>29,972,433.95</b>	<b>30,711,129.85</b>
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,972,433.95	30,711,129.85
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>1,955,587.54</b>
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>1,955,587.54</b>
Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,955,587.54
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>472,162,289.86</b>	-

<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>472,162,289.86</b>	<b>-</b>
Хаагдсан данс	472,162,289.86	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>181,372,319.10</b>	<b>5,470,876,603.21</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>70,840,184.75</b>	<b>69,185,240.64</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	70,840,184.75	69,185,240.64
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>19,309,190.20</b>	<b>2,727,389,066.72</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	19,309,190.20	28,858,066.72
Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	-	2,698,531,000.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>232,903,313.65</b>	<b>2,812,672,777.13</b>

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,106,734,488.46</b>	<b>3,558,649,935.35</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,106,734,488.46</b>	<b>3,558,649,935.35</b>
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,106,734,488.46</b>	<b>3,558,649,935.35</b>
<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,106,734,488.46</b>	<b>3,498,649,935.35</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,651,684.40	17,151,158.50
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,096,082,804.06	3,481,498,776.85
Бусад орлого	-	60,000,000.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>434,249,973.64</b>	<b>1,445,845,630.36</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>434,249,973.64</b>	<b>1,445,845,630.36</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>434,249,973.64</b>	<b>1,443,890,042.82</b>
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>44,368,181.80</b>
Байрны түрээс	-	44,368,181.80
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	<b>12,760,512.01</b>
Бичиг хэрэг	-	1,044,205.44
Тээвэр, шатахуун	-	1,000,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	4,844,154.50
Ном, хэвлэл	-	2,667,700.27
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,204,451.80
<b>Томилолт, зочны зардал</b>	-	<b>40,660,531.26</b>
Гадаад албан томилолт	-	27,030,340.26
Дотоод албан томилолт	-	13,630,191.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>434,249,973.64</b>	<b>1,346,100,817.75</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	434,249,973.64	1,346,100,817.75
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>1,955,587.54</b>
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>1,955,587.54</b>
Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,955,587.54
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>672,484,514.82</b>	<b>2,112,804,304.99</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>470,577,526.44</b>	<b>1,172,151,228.51</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>470,577,526.44</b>	<b>1,172,151,228.51</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>470,577,526.44</b>	<b>1,172,151,228.51</b>
Барилга байгууламж	0.00	1,169,852,410.33
Тоног төхөөрөмж	467,177,526.44	0.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,400,000.00	2,298,818.18
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(470,577,526.44)</b>	<b>(1,172,151,228.51)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>51,530,994.54</b>	<b>40,327,173.92</b>
<b>Бусад эх үүсвэр</b>	<b>70,840,184.75</b>	<b>69,185,240.64</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	70,840,184.75	69,185,240.64
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>19,309,190.21</b>	<b>28,858,066.72</b>
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	19,309,190.21	28,858,066.72
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>253,437,982.92</b>	<b>980,980,250.40</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,180,662,687.54	1,434,100,670.46
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,434,100,670.46	2,415,080,920.86

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>1,606,650,730.10</b>	<b>1,606,650,730.10</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>1,606,650,730.10</b>	<b>1,606,650,730.10</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	2,812,672,777.13	2,812,672,777.13
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>4,419,323,507.23</b>	<b>4,419,323,507.23</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>5,751,031,900.00</b>	<b>5,574,412,685.13</b>	<b>176,619,214.87</b>	<b>96.9</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,621,430,000.00</b>	<b>1,446,188,861.00</b>	<b>175,241,139.00</b>	<b>89.2</b>
Бараа, үйлчилгээний зардал	1,621,430,000.00	1,446,188,861.00	175,241,139.00	89.2
<b>Байр ашиглалттай холбоотой зардал</b>	<b>44,400,000.00</b>	<b>44,368,181.80</b>	<b>31,818.20</b>	<b>99.9</b>
Байрны түрээс	44,400,000.00	44,368,181.80	31,818.20	99.9
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,900,000.00</b>	<b>12,760,512.01</b>	<b>8,139,487.99</b>	<b>61.1</b>
Бичиг хэрэг	1,200,000.00	1,044,205.44	155,794.56	87.0
Тээвэр (шатахуун)	2,800,000.00	1,000,000.00	1,800,000.00	35.7
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,900,000.00	4,844,154.50	55,845.50	98.9
Ном, хэвлэл	6,000,000.00	2,667,700.27	3,332,299.73	44.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	6,000,000.00	3,204,451.80	2,795,548.20	53.4
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>135,600,000.00</b>	<b>40,660,531.26</b>	<b>94,939,468.74</b>	<b>30.0</b>
Гадаад албан томилолт	120,000,000.00	27,030,340.26	92,969,659.74	22.5
Дотоод албан томилолт	15,600,000.00	13,630,191.00	1,969,809.00	87.4
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>1,420,530,000.00</b>	<b>1,348,399,635.93</b>	<b>72,130,364.07</b>	<b>94.9</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>4,129,601,900.00</b>	<b>4,128,223,824.13</b>	<b>1,378,075.87</b>	<b>100.0</b>
<b>Дотоод эх үүсвэрээс</b>	<b>4,129,601,900.00</b>	<b>4,128,223,824.13</b>	<b>1,378,075.87</b>	<b>100.0</b>
Барилга байгууламж	1,798,657,400.00	1,797,674,324.13	983,075.87	99.9
Тоног төхөөрөмж	2,330,944,500.00	2,330,549,500.00	395,000.00	100.0%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,751,031,900.00</b>	<b>6,439,870,190.65</b>	<b>(688,838,290.65)</b>	<b>112.0</b>
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>5,751,031,900.00</b>	<b>6,439,870,190.65</b>	<b>(688,838,290.65)</b>	<b>112.0</b>
Туслах үйл ажиллагаанаас санхүүжих	-	75,195,570.96	(75,195,570.96)	100
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,751,031,900.00	6,439,870,190.65	(688,838,290.65)	112.0
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>1,434,100,670.46</b>	<b>(1,434,100,670.46)</b>	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>2,415,080,920.86</b>	<b>(2,415,080,920.86)</b>	

<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1		
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	8	8		
Удирдах ажилтан				
Гүйцэтгэх ажилтан	8	8		